

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН

*/9 сар/*

Чойр 2019 он


# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2019-09-24

WEB [/govisumber@nso.mn/](http://govisumber@nso.mn/), Face book /Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс/ хаягаар хэлтсийн танилцуулга, инфографик зэрэг бүтээгдэхүүнүүдийг цаг тухайд нь байршуулан хэрэглэгчдэд сурталчилж байна. Аймгийн WEB хуудсанд холбогдсон учир [govisumber@gov.mn](http://govisumber@gov.mn) хаягаар мэдээлэлтэй танилцах боломжтой.

- 2019 оны 8 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж аймгийн болон хэлтсийн вэб хуудсанд байршуулав.
- 2019 оны 8 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгаар хэвлэлийн бага хурлын материал болон инфографик бэлтгэн хэлтсийн вэб болон face book хуудсанд байршуулав.
- Мөн инфографик бэлтгэж хэлтсийн вэб хуудсанд байршуулж сурталчиллаа.
- Дундговь аймагт зохион байгуулагдсан Байшин, орон сууцны тооллогын сургагч багш бэлтгэх сургалтанд хэлтсээрээ хамрагдав.
- Байшин, орон сууцны тооллогын тоологч нарын сургалтыг Сүмбэр суманд, сум, багийн тооллогын түр товчооны ажилтнуудын сургалтыг сумдад нь зохион байгуулав.
- Тооллоготой холбоотой сурталчилгааны ажлыг багийн түр товчоодтой хамтран зохион байгуулж байна.
- Хүн ам, орон сууцны тооллого болон байшин орон сууцны тооллогын 6 төрлийн сурталчилгааны материал 1000 орчмыг, 2 төрлийн баннер хэвлэсэн байна.
- Нийтийн номын сантай хамтарч номын баяр, сурталчилгааны өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр 200 орчим сурталчилгааны материал бэлтгэж тараав.
- Мөн ерөнхий боловсролын сургуулиудын номын санд Статистикийн үйл ажиллагааг сурталчилж материал бэлтгэж өгөв.
- “Номтой дугуйн зогсоол” болон “Авсан ч болно, өгсөн ч болно” буланд сурталчилгааны материал бэлтгэн байршуулан тархаав.
- Ажиллах хүчний судалгаанд Сүмбэр сумын 2 багийн 20 өрх, Шивээговь сумын 1 багийн 10 өрх хамрагдлаа.

**Говьсүмбэр аймгийн 2019 оны 8 дугаар сарын инфографик.**  
Нийтэлсэн: 2019 он 09 сар 13, 02 цаг 34 минут




Говьсүмбэр аймгийн 2019 оны 8 дугаар сарын инфографик хэвлэгдлээ. [Дэлгэрэнгүй](#)

**Говьсүмбэр аймгийн 2019 оны 8 дугаар сарын хэвлэлийн бага хурал.**  
Нийтэлсэн: 2019 он 09 сар 13, 01 цаг 49 минут




Говьсүмбэр аймгийн 2019 оны 8 дугаар сарын хэвлэлийн бага хурал. [Дэлгэрэнгүй](#)

**Говьсүмбэр аймгийн 2019 оны 8 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга хэвлэгдэн гарлаа.**  
Нийтэлсэн: 2019 он 09 сар 13, 01 цаг 11 минут



Ердийн хөдөлгөөн Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 8 сарын сайдлаар 285 эх амаржиж, 289 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 33 буюу 10.8 хувиар, төрсөн хүүхдийн тоо 39 буюу 9.4 хувиар тус тус буурсан байна. Нас баралт 46, бүртгүүлсэн гэр бүл 48, цуцалсан гэр бүл 19 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 6 буюу 46.1 хувиар өсч, нас баралт 8 буюу 14.8 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 15 буюу 23.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 3 хүүхэд үрчлэгдсэн. 242 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 132 хүнээр буюу 35.3 хувиар буурсан байна. [Дэлгэрэнгүй](#)





### 2019 оны 8 дугаар сарын “Ажиллах хүчний судалгаа”-нд 30 өрх хамрагдлаа

Нийтэлсэн: 2019 он 08 сар 30, 09 цаг 18 минут

ТАЛАРХАЛ		
№	Өрхний нэр	Өрх
1	Т.ОЮУНБААТАР	4
2	Д.СЭНГЭЛЭН	4
3	Д.СЭНГЭЛЭН	4
4	С.АМГАН	4
5	М.ДЭЛГЭРЭЛ	4
6	М.ДЭЛГЭРЭЛ	4
7	А.ТӨГСӨМӨР	4
8	А.ТӨГСӨМӨР	4
9	Д.ОЮУНБААТАР	4
10	Д.ОЮУНБААТАР	4
11	С.ОЮУНБААТАР	4
12	Д.ОЮУНБААТАР	4
13	Д.ОЮУНБААТАР	4
14	С.ОЮУНБААТАР	4
15	С.ОЮУНБААТАР	4
16	С.ОЮУНБААТАР	4
17	С.ОЮУНБААТАР	4
18	С.ОЮУНБААТАР	4
19	С.ОЮУНБААТАР	4
20	С.ОЮУНБААТАР	4
21	С.ОЮУНБААТАР	4
22	С.ОЮУНБААТАР	4
23	С.ОЮУНБААТАР	4
24	С.ОЮУНБААТАР	4
25	С.ОЮУНБААТАР	4
26	С.ОЮУНБААТАР	4
27	С.ОЮУНБААТАР	4
28	С.ОЮУНБААТАР	4
29	С.ОЮУНБААТАР	4
30	С.ОЮУНБААТАР	4

2019 оны 8 дугаар сарын “Ажиллах хүчний судалгаа”-нд Сүмбэр сумын 4-р багийн 10 өрх давтан сонгогдсон ба Сүмбэр сумын 2-р багийн 10 өрх, Шивээговь сумын 2-р багийн 10 өрх тус тус шинээр сонгогдож нийт 30 өрх хамрагдлаа. Судалгаанд сонгогдсон айл, өрхүүдэд судалгааны ач холбогдлыг танилцуулж, ХАОС-2020 оны ээлжит тооллого, Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн талаарх зарим тоон мэдээллийг өгч, судалгааны мэдээллийг цуглуулан ажиллалаа. Ажиллах хүчний судалгаа нь хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээллийг цуглуулж, төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг үнэн бодит, тоо мэдээллээр хангахад чиглэсэн чухал ач холбогдолтой юм. Энэхүү судалгааны ач холбогдлыг ойлгож, үнэн бодит мэдээлэл өгсөн нийт өрхийн гишүүд болон судалгааны хөтчөөр ажилласан Сүмбэр сумын 4-р багийн Засаг дарга Т.Одгэрэл, Шивээговь сумын 2-р багийн Засаг дарга С.Отгонбаатар, Сүмбэр сумын 2-р багийн нийгмийн ажилтан Д.Саранцэцэг нартаа талархал илэрхийлье.

[Дэлгэрэнгүй ▶](#)

Мэдээлэл бэлтгэсэн: Ахлах мэргэжилтэн

Я.Отгонбаяр